

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг
зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн
Хорьдугаар хуралдааны тэмдэглэл /2021-12-21/**

Монгол улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн 20 дугаар хуралдаан 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 10 цагт цахимаар зохион байгуулагдав.

Хуралдаанд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргалыг орлож мөн яамны Судалгаа, хөрөнгө оруулалтын газрын дарга Э.Батболд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдыг орлож мөн яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын ахлах мэргэжилтэн Б.Буяннэмэх, Үндэсний аудитын газрын дарга Д.Занданбатыг орлож Аудитын нэгдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Энхжавхлан, Авлигатай тэмцэх газрын дарга З.Дашдавааг орлож ажилтан Б.Сүрэнжав, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдавааг орлож Макро эдийн засгийн газрын дарга Э.Эрдэнэсан, мэргэжилтэн Б.Тэгшжаргал, Эрдэнэт үйлдвэрийн Төлөөлөгчийн газрын орлогч захирал Г.Тамир, Монполимет ХХК Группын гүйцэтгэх захирал С.Энхтуяа, Монголросцветмет ХХК-ийн тэргүүлэх мэргэжилтэн М.Болдбаатар, Оюутолгой ХХК-ны ахлах менежер Э.Лхагвыг орлож Хамтын ажиллагааны ахлах менежер Т.Мөнхбат, Энержи ресурс ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Батцэнгэлийг орлож менежер З.Сугармаа, Нээлттэй нийгэм форумын захирал П.Эрдэнэжаргалыг орлож менежер Д.Эрдэнэчимэг, Транспаренси Интернэйшил байгууллагын ерөнхийлөгч Л.Төр-Од, Хүний эрх хөгжил төвийн тэргүүн Г.Уранцоож, Хил хязгааргүй алхам ТББ-ийн тэргүүн Н.Баярсайхан, Ил тод сангийн тэргүүн Д.Цэрэнжав, Захиргааны шинэ санаачилга ТББ-ын тэргүүн С.Цэрэнпүрэв, Их баян шарга ТББ-ын тэргүүн Л.Бор нар оролцов.Хуралдаанд Үндэсний зөвлөлийн 33 гишүүдээс 19 гишүүд оролцож ирц 57,6 хувьтай байв.

Мөн хуралдаанд Грант Торnton Аудит ХХК-ийн захирал Б.Осоргарав, партнер Н.Эрдэнэцог болон бусад аудиторууд, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын ахлах байцаагч Л.Цэвээнравдан, Хүний хөгжил сургалт судалгааны төвийн гүйцэтгэх захирал Г.Цэрэнжаргал, АХБ-ны Олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах төслийн зохицуулагч З.Баярхүү, Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, санхүүгийн ажилтан А.Отгонтунгалаг, мэдээллийн технологийн зөвлөх В.Нармандах, харилцааны мэргэжилтэн З.Цэлмэг нар оролцов.

Монголын ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийн хорьдугаар хуралдааныг, Үндэсний зөвлөлийн дарга, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нээж үг хэлэв.

Г.Ёндон: Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Үндэсний зөвлөлийн гишүүд Та бүхэнд Монгол Улсын Засгийн газар, УУХҮЯ-ны нэрийн өмнөөс болон хувиасаа чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлж, удахгүй болох салбарын 99 жилийн ойн мэнд хүргэе. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОҮИТБС)-ыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн 20 дахь удаагийн хуралдааныг нээж байгаадаа баяртай байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам Монгол Улсад ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх замаар эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулж, эдийн засгийн

тэнцвэртэй олон тулгуурт бүтцийг бий болгох зорилтын хүрээнд салбарын талаарх хууль тогтоомж, бодлого, дунд, урт хугацааны стратеги, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг боловсруулах, хэрэгжилтийг хангах ажлыг үе шаттай зохион байгуулж байна.

Улс орны нийгэм, эдийн засагт олборлох үйлдвэрлэлийн салбар томоохон хувь нэмэр оруулж, 2021 оны 11 дүгээр сарын байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 24 хувь, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 68 хувь, экспортын 94 хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 76 хувь, улсын төсвийн орлогын 29 хувийг дангаараа бүрдүүлж байна. Монгол Улсын Үндсэн хуульд “байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ.

Иргэд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй” гэж заасны дагуу иргэдийн эрхийг сахин хамгаалах, улс орны эдийн засгийн өсөлтийг хангах, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг нэмэгдүүлэхэд “ил тод байдлын санаачилга” чухал үүрэг, оролцоотой билээ.

Монгол Улс 1990 оноос зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээр ашигт малтмалыг хайх, ашиглах үйл ажиллагааг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд тусгай зөвшөөрөл, гэрээний дагуу эрхлэх боломжтой болж, үүний үр дүнд салбарын үйл ажиллагаа өргөжин тэлж, улс орон нутгийн төсвийн дийлэнх хувийг бүрдүүлж байна. Гэсэн хэдий ч ил далд данс хөтлөх, татвар төлөхөөс зайлсхийх байдлын улмаас төсвийн орлого буурах, бүртгэлгүй мөнгөн урсгал бий болох үзэгдэл байсаар байна.

Энэ байдлыг арилгах, таслан зогсооход 2006 оноос хэрэгжүүлж эхэлсэн ОҮИТБС-ын жил бүрийн нэгтгэл тайлан, түүний үр дүн тодорхой үүрэг гүйцэтгэж ирснийг цохон тэмдэглэхэд таатай байна. Энэ хуралдаанаар 15 дахь удаагийн тайланг хэлэлцэх юм. Цаашид ОҮИТБС-ын хүрээнд төрийн байгууллагуудын уялдаа, холбоог сайжруулах, ашиг хүртэгч эздийг ил тод болгох зэрэг чиглэлээр тодорхой ажлууд хийгдэнэ. Үүний тулд 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд оруулах асуудлыг бодитой хэрэгжихүйц байлгах талаас нь Үндэсний зөвлөлийн гишүүд Та бүхэн санал бодлоо солилцож, хуралдаандаа идэвхтэй оролцоно гэдэгт итгэлтэй байна. Хуралдааны үйл ажиллагаанд амжилт хүсье. Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай.

1. ХЭЛЭЛЦСЭН НЬ: Монгол Улсын ОҮИТБС-ын 2020 оны нэгтгэл тайлангийн төслийн танилцуулга

Н.Эрдэнэцог: Сайн байцгаанаа уу, та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргээ. Өнөөдөр бид ОҮИТБС-ын 15 дахь удаагийн нэгтгэл тайлангийн танилцуулгыг хийх гэж байна. Ажлын хэсгийн гишүүдийн саналын дагуу өнөөдөр дахин уулзаж, нэгтгэл тайлангийн танилцуулгыг хийж байна. 2020 оны нэгтгэл тайланг уян хатан тайлагнагналын хэлбэрээр гаргахаар ОТАХ сонгосон. Уян хатан тайлагнагналын талаар товч тайлбарлай.

Ковидтой холбоотойгоор ОҮИТБС-ын ОУНБДНГ-аас 2022 оны 12 дугаар сарын 31-ныг хүртэл уламжлалт болон уян хатан байдлаар нэгтгэл тайланг бэлтгэх журам гарсан ба энэ хоёр аргын алийг нь ч ашиглах боломжгүй бол ОТАХ зөвшилцөөд тайлангийн хугацааг хойшлуулах боломжтой байна. Уян хатан тайлагнад Олон улсын хороотой тайлангийн процесс эхлэхээс өмнө зөвшилцэж, баримтжуулах ёстай. Үүнд,

коронавируст халдварт (COVID-19), түүхий эдийн үнийн уналт зэрэг олборлох салбарын өнөөгийн болон хэтийн төлөвийн талаарх мэдээлэл; мэдээллийн чанар, баталгаатай холбоотой заалтуудыг эс тооцвол ОҮИТБС-ын шаардлагуудын дагуу ЗГ эсвэл компаниудын нэг талын мэдээллээр ил тод болгож болно. (нэгтгэл хийхдээ аль болох уян хатан байх); хамгийн сүүлийн үеийн үйлдвэрлэл, экспорт, орлогын мэдээллийг ил тод болгох; олон улсын хорооноос гаргасан дата мэдээллийн хураангуй; ОҮИТБС-ын 2019 оны стандартын дагуу тодруулгад ямар нэг дутагдал, сул талыг илрүүлж, ил болгосон мэдээллийн цогц, найдвартай байдлын үнэлгээг ОТАХээс гаргах талаар заасан байна. Уян хатан тайлангийн ажлын даалгаварт: 1) Мэдээлэл цуглуулах, түгээх ажлыг ямар нэг эрүүл мэндийн эрсдэлгүй хийх; 2) ОҮИТБС-ын тайлагналыг хялбаршуулах, цаг хугацааны хувьд уян хатан хандах; 3) ОТАХ-ээс уян хатан тайлагналын хүрээнд алт, зэс, нүүрсний 60 орчим компанийг нэгтгэх гэж тусгасан байна. Уян хатан нэгтгэл тайланд ОТАХ маш чухал үүрэгтэй оролцох бөгөөд тайлантай танилцаад стандартын дагуу байна уу, ямар заалт дутуу байна зэргээр саналаа солилцож, хараат бус нэгтгэгчид саналаа хэлж, залруулах, засуулах байдлаар хамтарч ажиллах хэрэгтэй байна.

2020 оны уян хатан нэгтгэл тайланг 2 талын мэдээллээр, 60 гаруй компанийг хамруулан хийж байна. Нэгтгэлд хамрагдсан компаниас нэг компани огт холбогдоогүй бол хоёр нь бусад шалтгааны улмаас хариу ирүүлээгүй. Энэ талаар бид ажлын хэсгийн хурал дээр танилцуулж байсан ч түүнээс хойш 14 хоногийн хугацаанд ямар ч ахиц гараагүй хэвээрээ байна. Эдгээр компанийт холбоотой 545 сая төгрөгийн зөрүүг шийдэж чадаагүй, энэ нь Засгийн газрын орлогын 0,02 хувийг эзэлж байгаа юм.

ОҮИТБС-ын стандартын 4,1 д төлбөр орлогын мэдээллийн талаар тусгах бол орлогын бус мэдээлэл нь шаардлагын 2-6 буюу 24 шаардлага байдаг. Ажлын цар хүрээний ихэнх буюу 70 гаруй хувь нь энэ ажил дээр зарцуулж байдаг. Цаашдаа төлбөр орлогын бус мэдээлэл дээр цаг хугацаагаа зарцуулах шаардлагатай байгаа тул ажлын даалгавар дээр өөрчлөлт оруулах санал байгаа. 2021 онд эрдэс баялагийн салбараас улсын төсөвт төвлөрсөн орлого 3,2 их наяд төгрөг хүрч, өнгөрсөн оноос 499 сая төгрөг буюу 19 хувиар буурсан байна. Нэгтгэлд хамрагдсан 60 компанийн нийт орлого 2,7 их наяд, харин 527 тэрбум төгрөгийг нэгтгэлд хамрагдаагүй компаниуд бүрдүүлсэн байна.

Нэгтгэл тайлангийн хүрээнд хийсэн төлбөр, орлогын анхны нэгтгэлээр 27.9 тэрбум төгрөгийн цэвэр зөрүү үүссэн бөгөөд цааш задалбал 465.1 тэрбум төгрөгийн нийт зөрүү үүссэн. ЗГ-ын дунд 362.4 тэрбумын нэмэгдэх тохиуулга, компанийн дунд 346.2 тэрбум төгрөгийн нэмэгдэх тохиуулгыг тус тус хийсэн. Ингэснээр өнөөдрийн байдлаар цэвэр зөрүү нь 11.2 тэрбум, нийт зөрүү нь 14.4 тэрбум болж буурсан байна. Үүнээс томоохон зөрүү үүсгэж буй зөрүү нь АМНАТ-өөс, дараагаар нь орон нутгийн төлбөрүүдээс шалтгаалж байгааг харж болно. Одоогоор зөрүүг тохиуулахад шаардлагатай мэдээллийг зөвхөн ГЕГ-аас ирүүлээгүй бөгөөд бусад ЗГ-ын байгууллагуудаас ирүүлсэн байна. Цахим тайлангийн системээр нийт тусгай зөвшөөрөл эзэмшиж буй 2363 компаниас 1419 компани нэмэлт мэдээллийн маягтаар тайлангаа илгээсэн. Энэ нь өмнөх онтой харьцуулахад дэвшилттэй боловч тайлагнавал зохих компаниудын 60 хувь нь тайлагнасан үзүүлэлттэй байна.

ОҮИТБС-ын стандартын дагуу орлогын бус мэдээллийн 25-ыг стандартын дагуу бид мэдээллийг, заримыг нь цахим тайлангаас, заримыг нь төрийн байгууллагаас албан бичгээр авч тайланд нэгтгэж оруулсан. Нийт 25 мэдээллийг компаниуд нэмэлт мэдээллийн маягтаар цахим тайланд оруулах ёстой. Үүнээс 23 маягтаар мэдээлэл ирүүлсэн 2 маягт ор хоосон байна. Энэ нь бүтээгдхүүн хуваах гэрээ болон төрийн

болон орон нутгийн компаниар хийсэн тээврийн маягт бөглөөгүй байгаа нь 2020 онд ийм ажил хийгдээгүй байна.

Баталгаажуулалтын ажлыг Олон улсын нарийн бичгийн даргын гэрээ байгуулж хамтран ажиллаж буй Баталгаажуулагчид гүйцэтгэдэг. Зорилго нь Монгол улс ОҮИТБС-ын стандартыг хэрэгжүүлж буй эсэхэд үнэлгээ хийх зорилготой. ОҮИТБС-ын ОУНБГ-ын газраас 2019 оны тайланг урьдчилсан байдлаар үнэлээд үүний дагуу 97 төрлийн дутуу, ойлгомжгүй асуудлыг запруулж, сайжруулах зөвлөмж өгсөн байна. Энэхүү зөвлөмжөөр баталгаажуулалтын маягтыг бөглөх, мөн 2019 оны тайланд өгсөн саналд үндэслэн, 2020 оны тайланд холбогдох нэмэлт өөрчлөлтүүдийг хийхээс гадна төрийн байгууллагуудаас нэмэлтээр тодруулах, ажлын албатай зөвшилцөх асуудлууд байна. Үүнд: 1) Материаллаг байдлын тодорхойгүй байдал. Үүнд: тээврийн орлого, бэлэн бус орлого, төсвийн шинжтэй зарцуулалт болон ЗГ-ын нийт орлогын урсгалууд гэх мэт.2) Бүх орлогын урсгалуудын хувьд төслийн төвшнөөр мэдээлээгүй байна гэсэн асуудлыг ОТАХ-тэй зөвшилцэж, нэгтгэл тайлан тусгах юм. Бид 2019 оны тайланд шүүлт хийгээд дутуу мэдээллийг гаргаж, мэдээллээ ирүүлээгүй газруудтай уулзалт хийж, мэдээллээ нөхөж ирүүлэхийг хүссэн боловч одоог хүртэл ирүүлээгүй байна. Мөн баяжуулах болон боловсруулах үйлдвэрийн талаарх мэдээлэл, туслан гүйцэтгэгч нарын мэдээллийг тайланд оруулах талаар яригдаж байгаа, одоо судалж байна.

Ажлын хэсгийн гишүүдээс 2020 оны нэгтгэл тайлангийн талаар имэйлээр ирсэн тодруулга асуултын хариуг өгсөн байгаа. Баяжуулах салбарын талаарх мэдээллийг оруулах байсан боловч мэдээлэл ирүүлээгүй. 2020 оны нэгтгэл тайланг хийхэд гарсан хүндрэл бэрхшээлийн талаар төрийн байгууллагууд мэдээллээ өгөхгүй байх, дутуу өгөх, шаардсан мэдээллийг ирүүлэхдээ хугацаа алдах, төрийн байгууллагууд ач холбогдол өгөхгүй байх, гаргасан мэдээллүүд хоорондоо зөрүүтэй байх, Засгийн газрын яам, агентлагуудын цахим тайланд оруулсан мэдээлэл буруу эсвэл дутуу дүнгээр тайлагнасан байх зэрэг хүндрэл гарсан.

Нэгтгэл тайлангаар Цахим тайлангийн мэдээллийн системийг улам боловсронгуй болгож тайланд шаардлагатай бүх мэдээллийг оруулах, ашигт малтмал тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээллийн сан нь хүчин төгөлдөр эсэхийг нягталж байх, олон талт ажлын хэсгийн бүрэлдэхүүнд жендерийн тэнцвэрийг хангахын тулд оролцогч тал бүрийн төлөөлөлтэй хэлэлцүүлэг хийж, арга хэмжээ авах, ОҮИТБС-ын Дэд зөвлөлийн санхүүжилтийн шийдвэртэй холбоотой Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах талаар ажиллах, тайлангийн маягтыг сайжруулах, ашиг хүртэгч эздийн мэдээллийг сайжруулах зэрэг зөвлөмжүүдийг өгсөн байна. Бид өмнөх 2019 оны ОҮИТБС тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг судалж, гүйцэтгэл болон тайлбарыг тайланд оруулсан. 2020 оны тайлангаар дараах зөвлөмжүүдийг өгсөн байна. Үүнд: Эрдэс баялагийн ил тод байдлын тухай хуулийг батлуулах, цахим тайлангийн иж бүрэн байдлыг хангах, Засгийн газрын орлого болон компанийн тайлагналын хоорондын зөрүүгийн асуудал, ОҮИТБС-ын стандартын дагуу төсөл тус бүрээр тайлагнах маягтыг сайжруулах гэсэн зөвлөмжүүдийг өгсөн байна. Анхаарал тавьсанд баярлалаа. /Тайлангийн төсөл, танилцуулгыг хавсаргав/

Э.Батболд: За танилцуулга хийсэн Эрдэнэцогд баярлалаа. Энэ удаагийн тайлан өмнөх тайлангуудаас ямар онцлог, шинэлэг тайлан болсон бэ?

Э.Эрдэнэсан: Төрийн байгууллагууд тайлагнахгүй байна гэж байна. УАГ-т тайлангаа хүргүүлж болох уу?

Н.Эрдэнэцог: Стандартын дагуу тушаасан тоон мэдээлэл нь үнэн зөв байх ёстой гэсэн шаардлагыг тавьдаг. Хоёр талаас гарсан тайланг хараат бус нэгтгэгч хянаад зэрүүг багасгах тал дээр ажилладаг. Яваандаа хоёр талаас гарч байгаа тоон мэдээлэл үнэн зөв бол Хараат бус нэгтгэгч шаардлагагүй, Ажлын алба өөрөө нэгтгэх боломжтой болно гэж байгаа. Иймд УАГ бидний бэлтгэсэн тайланг хянах бус Засгийн газрын хянагдсан тайлантай тулгах хэрэгтэй байгаа юм. Цахим тайлангийн 40 гаруй мэдээллийн татвар хураамжийн маяглаар төрийн 15 байгууллага тайлан гаргадаг. Үүнээс хамгийн их буюу нэг их наяд төгрөгийн орлогыг Татварын ерөнхий газар хүлээн авснаа татварын орлогын төрлөөр ангилж тайлагнадаг. Энэ тайлангаа үнэн зөв бэлтгэсэн гээд удирдлагын гарын үсэгтэй баталж ирүүлдэг боловч энэ нь заавал дахин тохируулга хийгддэг. Ямар нэг байдлаар зэрүү, илүү, дутуу тайлагнасан байдаг. Ийм учраас тоон мэдээллийн чанарыг сайжруулах талаар ОТАХ үнэлгээ хийж, шийдвэр гаргах ёстой гэдгийг заасан байгаа.

Ц.Энхжавхлан: Танай 2021 оны тайлан хэзээ гарах вэ? Дараа оны хэдэн сард бэлэн болох вэ?

Ш.Цолмон: 2021 оны тайланг 2022 оны 10 дугаар сард бэлэн болгохоор ажлын төлөвлөгөөнд тавьсан байгаа.

Ц.Энхжавхлан: Бид санхүүгийн аудитын тайланг 2022 оны 6 дугаар сард төсвийн гүйцэтгэлийн тайланг Засгийн газарт танилцуулдаг. Иймд тендерийн ажлаа эртхэн эхлээд, төсвийн гүйцэтгэлийн тайлан гарахаас өмнө ОҮИТБС-ын тайлан мэдээ бэлэн болчихвол хаана ямар зэрүү байна гэдэгт дүгнэлт хийх боломжтой болов уу гэсэн санаа байна.

Н.Эрдэнэцог: Энэ ажлыг хийх боломжтой; төсвийн гүйцэтгэлийн тайлан гарахаас өмнө төрийн байгууллагууд ил тодын тайлангаа гаргачихсан байдаг.

Ц.Энхжавхлан: Нэгтгэл тайлангаар гарсан зэрүү дээр бид ажиллаж, цаашдаа энэ тоонууд нийлж байх тогтолцоог хөгжүүлэх нь чухал юм. Түүнээс тэр тоо зөв байна уу буруу байна уу гэдэг бидэнд хамаагүй. Тайлангаар үүсч байгаа зэрүүг судлаад, арилгах талаар дараагийн тайлангуудад анхаарах нь чухал байх.

Н.Эрдэнэцог: Бид жил бурийн тайлангийн зэрүүг тулгаад, хоёр талаас тайлбар тодруулга авч зэрүүг багасгаад тайлбарлагдаагүй маш бага хэмжээний зэрүү үлддэг. Анх үүсээд байгаа зэрүүг аль болох бага байлгахын тулд төрийн байгууллагуудын санхүүгийн аудитаар ил тодын тайланг давхар баталгаажуулах талаар ажлын даалгаварт оруулаад, хийдэг болох санааг бид тусгасан:

Ц.Энхжавхлан: Саналыг дэмжиж байна. Мөн надруу энэ тайлангаа болон танилцуулгуудыг имэйлээр ирүүлэхийг хүсье. Тайлантай танилцаж, ажлын даалгаварт оруулах боломж байгаа эсэхийг судалж үзье.

Н.Баярсайхан: Сайн байцгаанаа уу, ОҮИТБС-ын 2020 оны нэгтгэл тайлангийн цэвэр зөрүүг 527.0 сая төгрөг гэж ойлгосон, өмнөх 5 тайлангуудын зөрүүг харьцуулан харуулах боломжтой юу, мэдээлэл нь байгаа бол болно гэж бодож байна. Ажлын байрны ажиллах хүчний төлбөр нь 379 сая төгрөг байгаа юм байна. Энэ төлбөрийг сумдууд авч чадахгүй байгаа юм байна гэж ойлголоо, өөрөөр хэлбэл энэ төлбөр төвлөрөх газраа төвлөрөхгүй ХНХЯ дээр очдог учир зөрүү гарч байна гэж ойлголоо. Энэ талаарх заалт Ашигт малтмалын тухай хуулийн 43-т байдаг. Иймд энэ заалт хэрэгжихгүй байгаа талаар тайлангийн зөвлөмжид оруулах саналтай байна. Тайлан мэдээгээ гаргаж ирүүлэхгүй байгаа төрийн байгууллагуудад ямар хариуцлага тооцох вэ? Мөн тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын 40 хувь буюу 944 компани тайлангаа гаргаагүй, өөрөөр хэлбэл Ашигт малтмалын тухай хуулийн 48.10 дугаар заалтыг хэрэгжүүлээгүй байна гэсэн дүгнэлтийг тайландаа оруулах саналтай байна. Эдгээр тайлан гаргаагүй 944 компанийд ямар хариуцлага тооцохыг УУХҮЯ- наас асууя. Нэмэлт мэдээллийн маятаас хоёр маягтыг огт бөглөөгүй гэж байна, энэ ямар учраас бөглөөгүй байна гэдгийг тодруулж өгөхийг хүсье.

Э.Батболд: Тайлан гаргаагүй компаниудад тооцох хариуцлага байхгүй, хууль батлуулах талаар ажиллаж байгаа.

Л.Бор: Тусгай зөвшөөрөл авчихаад тайлан гаргахгүй байгаад байдаг үүнийг хариуцлагатай болгох талаар зөвлөмжид оруулах саналтай байна.

Н.Эрдэнцог: Бөглөөгүй хоёр маягт байгаа энэ нь Бүтээгдхүүн хуваах гэрээний мэдээллийн маягт байдаг, 2020 онд БХГ хийгдээгүй учраас уг маягтаар тайлан гаргаагүй. Нөгөө маягт нь төрийн өмчит компаниудын хийсэн тээврийн мэдээлэл гэсэн бас ийм ажил хийгдээгүй учраас уг мэдээлэл бөглөгдөөгүй байна. Бор гишүүний саналыг жил бүрийн тайланд зөвлөмж болгоод оруулдаг боловч хууль батлуулаагүй учраас хэрэгждээгүй зөвлөмж байдаг. Иймд Эрдэс баялгийн ил тод байдлын тухай хуулийг батлуулах зайлшгүй шаардлагатай байна. ОҮИТБС-ын талаар сургалт, мэдээлэл сурталчилгааны ажлууд сайн хийгдэж байснаар ахиц гарч байгаа гэж харж байгаа. Ямар ч хуулийн зохицуулалтгүй байхад санаачилгаараа 60 гаруй хувь нь ил тодын тайлангаа гаргаж байгаа нь чамлахгүй амжилт юм. Цаана нь тайлан гаргахгүй байгаа компаниуд нь үйл ажиллагаа явуулдаггүй, Х тайлан өгдөг, лиценз эзэмшдэг цаасны компаниуд гэж харагдаж байгаа. Татвар хураамж төлдөг, идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг компаниудын ихэнх нь ил тодын тайландаа хамрагдаж байгаа, мэдээ баримтаас харахад ч тийм байгаа.

Ц.Уранцож: Ил тодын хууль үнэхээр чухал байгаа, хуулиа өргөн барих хэрэгтэй байна. Үндэсний зөвлөлөөс сайдад хандаж 2022 ондоо багтаан хуулийн төслийг өргөн барих шаардлага; хүсэлтийг гаргаж хүргүүлэх саналтай байна. Яагаад УУХҮЯ болон Ашигт малтмалын газар тайлангаа гаргахгүй байна вэ, энэ талаар бас хүсэлт хүргүүлэх саналтай байна. Баярлалаа.

Б.Буяннэмэх: ОҮИТБС ын ажлын албанаас ойр ойрхон хурал семинар зохион байгуулж, ил тод байдлыг сайжруулах гэж ажиллаж байгааг манай яам дэмжиж

ажилшаж байгаа. Манай яаманд уул уурхайн байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн ховор байдаг, одоо нэг л хүн ажиллаж байна. Миний хувьд ил тодын ажилд аль болох оролцохыг хичээдэг ч зарим тохиолдолд хүрэлцэхгүй байна. Байгаль орчны нөхөн сэргээлтийн асуудал, “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд компаниудын үйл ажиллагаа явагдаж байдаг. Иймд боломж байдаг бол манай яамны уул уурхайтай холбоотой асуудал хариуцсан мэргэжилтний хүн хүчийг нэмэгдүүлэх талаар санал оруулж өгөх хүсэлтэй байна, баярлалаа.

2. ХЭЛЭЛЦСЭН НЬ: Монголын ОУИТБС-ын 2021 оны ажлын төлөвлөгөөний биепэлтийн явц, 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийн тухай

Ш.Цолмон: Бид 2021 онд нийт 76 үйл ажиллагааг хийхээр төлөвлөсөн бөгөөд үүнээс 63 ажил хэрэгжсэн буюу хэрэгжих шатандаа явж байна, гүйцэтгэл 82 хувьтай байна. Тухайлбал, Эрдэс баялагийн ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн барихаар бэлтгэж байна, компани төрийн байгууллага, аймаг дүүргүүдийн 2020 оны ил тод байдлын тайланг гаргуулсан, 2020 оны нэгтгэл тайланг Грант Торnton аудит компанийтай гэрээлэн гүйцэтгэж, ажлын хэсэгт танилцуулсны дараа Үндэсний зөвлөлд танилцуулж байна, ОҮИТБС-ын цахим тайлагналын системийг Лидер Вишн групп шинэчлэх ажлыг хийсэн, Аймгуудын дэд зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор судалгаа, стратегийн үйл ажиллагаа боловсруулах ажлыг хийж сөн Ажлын хэсэгт танилцуулсан, Эрдсийн гэрээний сангийн журмыг УУХҮ-ны Сайдаар батлуулж, холбогдох сургалтыг зохион байгуулсан, ОҮИТБС-ын тайлангийн маягтад нэмэлт өөрчлөлт оруулахаар Ажлын хэсэг байгуулан, өөрчлөлтийг оруулж батлуулахаар Үндэсний статистикийн хороонд өргөн барьсан байна. Мөн аймгуудын дэд зөвлөлүүдтэй хоёр сар тутамд цахимаар уулзаж, хамтран ажилладаг болсон, Төв, Баруун болон Зүүн бүсийн чуулганыг цахимаар зохион байгуулж Баруун бүсийн чуулганд анх удаа АХА тэмцээнийг зохион байгуулсан, Говийн бүсийн дэд зөвлөлийн сургалтыг цахимаар зохион байгуулсан, “ил тод аймаг” шалгаруулах аяныг ОУСК, ТАН эвсэлтэй хамтран хамтран зохион байгуулах ажлын эхлүүлсэн бөгөөд 2022 оны нэгдүгээр улиралд дүнгээ гаргана. Мэргэжлийн холбоодтой зөвлөлдөж ил тод компани сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахаар бэлтгэж байна, ОҮИТБС-ын ОУНБДНГ-тай хамтран Баталгаажуулалтад бэлтгэж, цуврал семинаруудыг зохион байгуулсан. Байгалийн баялагийн засаглалын хүрээлэнтэй хамтран Авилгын эрсдэлийн судалгаа хийлгэж дүгнэлт гаргуулан зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөж байна. “Нээлттэй өмчлөгч” олон улсын байгууллага, ОҮИТБС-ын ОУНБДНГ-тай хамтран УУХҮЯ дээр “Олборлох үйлдвэрлэлийг нээлттэй болгох нь” 5 жилийн хөтөлбөрийг эхлүүлсэн зэрэг ажлуудыг хийсэн байна.

2022-2023 онуудад Дэлхийн банкны санхүүжилтээр ажиллахаар яриа хэлэлцээ хийгдэж байгаа. Үүнтэй холбогдуулан хуулийн төслийг батлуулах, хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах, ОУИТБС-ын тайлангийн системийг хэрэглэгч, хэрэглээ талаас нь сайжруулж, хөгжүүлэх, эцсийн өмчлөгчийн тайлагналын системийг бий болгөх, 2021 оны хэрэгжүүлж амжаагүй ажлыг 2022 он рүү шилжүүлэх, мэдээлэл харилцааны үйл ажлыг шинэ шатанд гаргах, 2021 оны нэгтгэл тайланг уян хатан байдлаар гаргах төсөв ажлыг шинэ шатанд гаргах, Баталгаажуулалтын үлдсэн ажлуудыг хийх, үнэлгээ хийгдэх зэрэг 50 сая төгрөг байгаа, Баталгаажуулалтын үлдсэн ажлуудыг хийх, үнэлгээ хийгдэх зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөж байна. 2022 онд мэдээлэл сурталчилгааг шинэ шатанд гаргах үйл ажиллагааны хүрээнд ОУИТБС-ын тайлан мэдээллийг аймаг, бүс, улсын хэмжээнд ойлгомжтой хураангуй хэлбэрээр бэлтгэх, түгээх, 2020 оны нэгтгэл тайлангийн онцлог үзүүлэлтээр видео шторк хийх, олон нийтэд түгээх, уул уурхайтай

сумын түвшний мэдээллээр сонин гаргах, жижиг аймаг сумын жишээг баримтжуулах, сайн түүхүүд жижиг хэмжээний ном гаргах, Говийн бүсийн ил тод байдлын аяныг дүгнэх, бүсийн чуулгануудыг шинэ арга барилаар зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Баярлалаа. /Танилцуулга, төлөвлөгөөг хавсаргав/

Э.Батболд: Ирэх оны төсөв төлөвлөгөө ямар байдалтай байна вэ?

Ш.Цолмон: 2022 оны улсын төсөв батлагдсан, АХБ- наас Ажлын албаны ажилтнуудын цалинг санхүүжүүлэхээр гэрээг сунгасан, Дэлхийн банкны санхүүжилтээр хийгдэх ажлын төлөвлөгөөний талаар Ажлын хэсгийн гишүүдээс хоёр удаа цахим хуудсаар санал авсан байгаа. Хэлэлцээр Сангийн яамаар зурагдах байх, энэ бүх үйл ажиллагааны зардлыг Дэлхийн банкнаас гаргахаар тусгасан.

3. ХЭЛЭЛЦСЭН нь:Дэд зөвлөлүүдийн чадавхийн суурь хэрэгцээний талаарх судалгааны хүрээнд боловсруулсан “Дэд зөвлөлийг чадавхжуулах стратеги”-ийн төслийн танилцуулга.

Г.Цэрэнжаргал: Манай судалгааны төвийн баг дээрх ажилд гэрээ байгуулан ажиллаж байна. Тус судалгааны зорилго нь Монголын ОҮИТБС-ын Дэд зөвлөлийн үйл ажиллагааны өнөөгийн бодит байдалд үнэлгээ өгөх, орон нутагт ил тод байдлыг хангахад тулгарч буй бэрхшээл, хэрэгцээг судалж, тодорхойлсны үндсэн дээр тайллан боловсруулж, цаашид дэд зөвлөлүүдийн үйл ажиллагааг хэрхэн сайжруулахад чиглэсэн зөвлөмж, стратеги, ажлын төлөвлөгөөний төслийг судалгааны хамт Монголын ОҮИТБС-ын Олон талт ажлын хэсэгт хүлээлгэн өгөхөд оршино.

Бидний ажил ганцаарчилсан ярилцлага, бүлгийн ярилцлага, асуулга, талбар стратеги төлөвлөгөөний төсөл боловсруулах ажлыг хийх байсан. Талбар дээрх ажлыг Дорноговь, Сэлэнгэ, Төв аймаг болон Бор-Өндөр суманд очиж ажилласан.

Судалгаандаа 21 аймгийн дэд зөвлөлийн гишүүдээс санал асуулга авч дүгнэлтийг гаргасан. Дэд зөвлөлийн 2021 оны төлөвлөгөөг судалсан. Үүнд нийт 253 ажлыг хийхээр төлөвлөсөн энэ нь нэг зөвлөл дунджаар 13 ажил гэсэн үг юм. Үүнээс мэдээлэх, олон талын оролцоотой хэлэлцүүлэг өрнүүлэх, төрийн байгууллагын үндсэн чиг үүргийн чанартай, дэд зөвлөлийн чиглэлтэй уялдаагүй 31 ажил байсан. Нийт Дэд зөвлөлийн гишүүдийн тоо дунджаар 10.5 үүнээс төрийн байгууллага 57 хувь, ИНБ 23хувь, хувийн хэвшил 20 хувийг эзэлж байна.

Дэд зөвлөлүүдийн төлөвлөгөө нь аймаг бүрийн төлөвлөгөөний үйл ажиллагааны чиглэлийн бүтэц ялгаатай, төлөвлөгөөнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, нэр тодорхой бус, хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг хэмжих шалгуур үзүүлэлт байхгүй, иргэдэд мэдээлэл өгөх арга хэлбэр нь нутгийн захиргааны цахим хуудсаар хязгаарлагдах, төрийн албан хаагчийн үндсэн чиг үүргийн ажлыг ажилласан төлөвлөгөөнд тусгасан байна.

Судалгаанд нийтдээ 46 хүн хамрагдсан, удирдлагын түвшний 11, төрийн байгууллагын 23, хувийн хэвшил 1, иргэний нийгмийн байгууллагын 11 хүн байв. Сүхбаатар, Завхан, Өмнөговь, Орхон аймгууд болон Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд Дэд зөвлөлүүдийн харьцаа тэнцвэртэй ажиллаж байна. Дэд зөвлөлүүдийн үйл ажиллагаанд хийсэн судалгаагаар Дэд зөвлөлийн засаглал оновчтой бус, үйл

ажиллагааны арга барил үйл явц хангалттай бүрдээгүй, мэдээллийн ил тод байдал хангагдаагүй гэсэн дүгнэлт гарсан.

Судалгааны үр дүнгээс дараах зөвлөмжүүдийг гаргасан байна. ОҮИТБС-ын Дэд зөвлөлийн үйл ажиллагааны цар хүрээг тодорхой болгох, ОҮИТБС-ын Дэд зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх ажлын хүрээнд Дэд зөвлөлийн нарийн бичгийг даргыг ИНБ-ийн төлөөллөөс томилж, цалин төсөвтэй байхаар баталж өгөх, Дэд зөвлөлийн санхүүжилтийг Засгийн газрын тогтоолын дагуу шийдвэрлэхийн зэрэгцээ Дэд зөвлөлд тодорхой үйл ажиллагаанд зориулан хөрөнгийн эх үүсвэрийг татаж төвлөрүүлэхийг дэмжих, ОҮИТБС-ын Дэд зөвлөлийг аргазүй, бусад санаачилга, төсөл хөтөлбөртэй уялдуулах, холбох үйл ажиллагааг Ажлын албанаас системтэй зохион байгуулах, ОҮИТБС-ын Дэд зөвлөлийн үйл ажиллагааг илүү тогтвортой, идэвхтэй болгох зорилгоор “ОҮИТБС-ын бүсийн зөвлөл” загварыг турших зэрэг зөвлөмжүүдийг боловсруулсан байна.

Дэд зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах үнэлгээ нь гурван хэсэгтэй. Ҳэсэг тус бүрийг хэрэгжүүлэх арга зүйн саналуудыг боловсруулж, стратегийг боловсруулсан байна. Стратеги нь бүтэц зохион байгуулалт, ил тод байдлыг хангах нь, нөлөөллийн үнэлгээ гэсэн хэсгүүдээс бүрдэнэ. Бүтэц зохион байгуулалтыг сайжруулахад гурван талын оролцоог тэгш хангах, орон тооны албан тушаалыг тодруулах үүний үр дүнд дэд зөвлөлийн үйл ажиллагааны үр дүн дээшилнэ, гишүүдийн чадавхи нэмэгдэнэ. Ил тод байдлыг хангахад ОҮИТБС-ын ач холбогдол, стандартыг таниулах, тодорхой нэг төрлийн бүтээгдэхүүн мэдээллийн сувгийг тодорхой болгох, ингэснээр ОҮИТБС-ын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг сайжирна, тайлagnalт сайжирна. Олон нийтийн нөлөөллийн үнэлгээг сайжруулах ажлын хүрээнд арга зүйг батлуулах, олон нийтэд таниулах, үнэлгээний ажлыг турших, судалгааны үр дүнд үндэслэн нөлөөллийг бууруулах арга хэмжээг авч ажиллах ажлыг хийхээр төлөвлөсөн үүний үр дүнд ОҮИТБС-ын нийгэмд үзүүлэх сөрөг нөлөө буурна, нийгмийн нөлөөллийн үнэлгээг журамлана. Дэд зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах аргазүйн саналын хүрээнд мэдрэмж бүрдүүлэх, оролцогч талуудын зураглал, тэргүүн туршлага нэвтрүүлэх, нийгмийн нөлөөллийн үнэлгээ, цахим хүртээмжтэй байдлын аудит хийлгэх ажлуудыг санал болгосон. Түүнчлэн эхний 1-2 жилд ашиглаж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хугацаатай нь санал болгон оруулсан байгаа, анхаарал тавьсан баярлалаа.

/Танилцуулгыг хавсаргав/

Э.Батболд: За баярлалаа, хурлын дэгийн дагуу хурлын шийдвэрт саналаа өгөхийг гишүүдээс хүсье, шийдвэрийн төслийг урьдчилж тараасан байгаа.

3. Цэлмэг: Хуулийн төслийн 2022 оны 2 дугаар сарын 15-наас өмнө Засгийн газрын хуралдаанаар оруулах тухай заалтыг хурлын шийдвэрт оруулах саналтай байна.

Э.Батболд: Тодорхой хугацаа тавьчихаар амжихгүй, биелэгдэхгүй байж магадгүй. Хуулийн төслийг өргөн барихад яамдуудаас санал авч, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт танилцуулах ёстой, цаг хугацаа орно, шийдвэрт яаж томъёолох саналаа ярилцаа.

Н.Баярсайхан: Цэлмэгийн саналыг дэмжиж байна, яагаад намрын чуулганд оруулж амжихгүй гэж? Яамдуудаас хэдий хугацаанд санал авдагийг бид мэднэ. Мөн ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийн хурлыг 2022 оны 1,2 дугаар сардаа багтааж танхимаар хийх саналыг хурлын тэмдэглэлд оруулмаар байна. ТАН эвслийн өгсөн албан бичигт зарчмын асуудлыг ярих, шийдвэр гаргах талаар тусгасан байгаа.

Өнөөдрийн энэ хуралдаан Үндэсний зөвлөлийн хурал биш, агуулгаараа ч тэр зарчмаараа ч тэр. Тайлан гаргаагүй компаниудад авах арга хэмжээ байхгүй гэж Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хүн хэлж байгаад үнэхээр гайхаж байна. Яам өөрөө мэдээллээ өгөхгүй, хариуцлага тооцохгүй, хууль биелүүлээгүй байхад яагаад хариуцлага тооцохгүй байна вэ? Ашигт малтмалын хуулийг хэрэгжүүлээгүй этгээдэд авах арга хэмжээ гэж байна, Зөрчлийн хууль гэж байхад, яагаад хууль хэрэгжүүлээгүй хүнд хариуцлага байхгүй гээд байна, тохуурхаад байгаа юмуу, яагаад байгааг би ойлгохгүй байна. Тийм учраас Үндэсний зөвлөлийн хурлаар бодлогын зарчмын асуудлуудыг шийдье, иймээс хурлын тэмдэглэлд Үндэсний зөвлөлийн хурлыг дараа оны нэгдүгээр улиралд багтаан бэлтгэл сайтайгаар танхимаар зохион байгуулах саналтай байна. Дэд зөвлөлийн стратегийг зөвхөн судалгааны байгууллага боловсруулаад саналаа оруулаад ирлээ, Ажлын хэсгийн хурлаар үүнийг ярихгүй байна. Иймээс дараагийн хурлаар стратегийг батлах нь зүйтэй гэж бодож байна. Өнөөдрийн хурал маш хариуцлагагүй хурал болж байна.

Э.Батболд: Хуралдааны тэмдэглэлийн төсөлд гишүүдээс хэлсэн саналыг нэмж тусгаад батлагдлаа гэж ойлголоо. Өөр саналтай гишүүд байвал бичгээр хүргүүлж болно.

3.Баярхүү: Ажлын албанаас тайлан гаргадаггүй компаниудад ямар хариуцлага тооцсон талаарх мэдээлэл өгөхийг албан бичгээр МХЕГ-т хандсан байгаа, хариу албан бичгээр ирсэн. Засгийн газрын тогтоол дээр ОУИТБС-ын тайлан гаргаагүй компаниудад авсан арга хэмжээний талаар МХЕГ-аас Үндэсний зөвлөлийн хуралд мэдээлэл хийж танилцуулна гэсэн байдаг. Өнөөдрийн хуралдаанд үндсэндээ оролцсонгүй.

ХЭЛЭЛЦСЭН нь:2020 оны ОУИТБС-ын тайлан гаргаагүй компаниудад авсан арга хэмжээний талаарх танилцуулга.

Л.Цэвээнравдан: Сайн байцгаана уу, МХЕГ- аас 12 дугаар сарын 17-ны өдөр албан бичгээр мэдээлэл хүргүүлсэн байгаа. Ашигт малтмалын тухай хуулийн 48.10 заалтыг биелүүлээгүй 22 аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуулийн 7.11.2.2 дахь заалтын дагуу торгуулийн арга хэмжээ авсан байна. Нийтдээ 22 аж ахуйн нэгжид 119.4 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

Н.Баярсайхан: Нэг компанийд хэдэн төгрөгийн торгууль ногдуулж байна вэ? Тайлан гаргуулах тал дээр ямар ажил хийж байна, зөрчлийг арилгуулах талаар ажиллах боломж байдаг уу?

Л.Цэвээнравдан: Нэг компанийг хуулийн дагуу 10 сая төгрөгөөр торгодог. Тайлангаа цаг хугацаанд гаргах талаар мэдээлэл, зөвлөгөө байнга өгдөг.

3.Баярхүү: Мэдээллийг харахад 2020 онд гуравхан компанийг торгосон байдаг гэтэл тайлангаа гаргаагүй 400 гаруй компани байсан. Иймээс бусад нь яасан, яагаад арга хэмжээ аваагүй талаар дэлгэрэнгүй тайлбарыг авах, цаашдаа яаж тайлан гаргуулах талаар танайхаас санал авахыг хүссэн. Хариуцлага тооцсон компаниудыг он, оноор нь мэдээлж болох уу?

Э.Батболд: Энэ тайлбар тодруулгаа бичгээр өгье, ямар ч хамаагүй асуудал яригдаад байна, хурлын тэмдэглэлд өгөх саналаа бичгээр хүргүүлж болно.

Л.Бор: Энэ асуудал нь ОҮИТБС-ын тайланг гаргуулах, өгөөжийг сайжруулахад хамгийн чухал юм. Бид хэдэн тоо, стандарт л яриад байдаг гэтэл ихэнх нь өгөхгүй байна. Өнөөдөр яагаад уул уурхай өгөөж байхгүй байна, ард түмний амьдрал дээшлэхгүй байна гэж бухимдаад байгаа нь энэ тайлангаа өгөхгүй байгаа асуудалтай холбоотой. Тийм учраас өнөөдөр ярьж байгаа асуудал чинь жинхэнэ холбоотой асуудал шүү.

Э.Эрдэнэсан: Төслийн зохицуулагчийн хэлснээр МХЕГ танилцуулах ёстой ажлаа хийхгүй байгаа юм байна. Тиймээс энэ тухай хуралдааны тэмдэглэлд оруулах саналтай байна. Мөн хэдэн компани, хэдэн жил торгуулсан, зөвхөн торгуулчихаад яваад байгаа юм уу тайлан гаргаагүй хэдэн компани байснаас хэд дээр нь ажиллагаа явуулсан зэрэг мэдээллийг дэлгэрэнгүй танилцуулах талаар оруулах хэрэгтэй.

Л.Цэвээнравдан: Бид жил бүр албан бичгээр мэдээллийг ажлын албанд хүргүүлдэг.

Э.Эрдэнэсан: Бидэнд ирээгүй.

З.Баярхүү: Засгийн газрын тогтоолд тайлан гаргаагүй компанид авсан арга хэмжээний талаар МХЕГ танилцуулахаар заасан байдаг, үүний дагуу мэдээлэл хийхийг хүссэн,

Л.Цэвээнравдан: За ойлголоо, удирдлагуудад уламжилъя, ер нь Ажлын алба болон бусад байгууллагуудад ажлын уялдаа холбоогоо сайжруулах ёстой юм байна, баярлалаа.

Э.Батболд: Өнөөдрийн хуралдаан үүгээр өндөрлөж байна, идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

Хуралдаан 12.10 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга,
ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийн
нарийн бичгийн дарга

Г.Нандинжаргал

Тэмдэглэлийг хянасан:

УУХҮЯ-ны Судалгаа, хөрөнгө оруулалт
газрын дарга

Э.Батболд

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ОҮИТБС-ын
Ажлын албаны зохицуулагч

Ш.Цолмон

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны санхүүгийн
ажилтан

А.Отгонтунгалаг

Чатаар ирсэн санал, сэтгэгдлүүд:

Н.Баярсайхан: УУХҮЯ 2018 оноос Үндэсний зөвлөлийг ахалж байгаагийн хувьд сайд өөрөө хурлыг ахалж баймаар байна.

Л.Төр-Од: ОҮИТБС-ын Үндэсний зөвлөл, ОҮИТБС-ыг Монгол улсад хэрэгжүүлэхэд УУХҮЯ, түүний дэргэдэх ОҮИТБС-ын Ажлын алба нь сүүлийн цар тахалтай хоёр жил багагүй сорилт бэрхшээл дунд боломжийн хүчин чармайлт гарган ажиллаж байгаад ТАН эвслийн зүгээс чин сэтгэлээс талархаж байна.

Манай улс 2006 онд санаачилгад элсэн орж ОҮИТБС-ыг харьцангуй амжилттай хэрэгжүүлсэн боловч 2018 оноос хойш улс төрийн манлайлал буурч Засгийн газрын тэргүүн, Ерөнхий сайдын өндөр түвшнээс УУХҮЯ-ны харьяалалд шилжсэнээр зэрэг гэхээсээ илүүтэй сөрөг үр дагавар ихээхэн гарах болсон нь туйлын харамсалтай.

УУХҮЯ нь ижил статустай бусад салбарын яамдад болон тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагуудад заавар чиглэл өгөх, үүрэг хариуцлага тооцох, шаардлага тавих, түүний мөрөөр хариу арга хэмжээ авах тал дээр багагүй бэрхшээлтэй тулгарч байгаа нь илт анзарагддаг. Энэ ч утгаараа сүүлийн жилүүдэд Үндэсний зөвлөл болон Олон талт ажлын хэсгийн гишүүн болох яамд, агентлагийн идэвх оролцоо, хүлээх хариуцлага эрс суларч байгаа нь нотлон харуулна.

Гэтэл ОҮИТБС-ын хэрэгжүүлэх олон улсын стандарт шаардлага улам бүр өндөржиж, эрдэс баялагийн салбарын засаглалыг илүү сайжруулж, Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэхэд энэхүү чухал салбарын үзүүлэх дэмжлэгийг сайжруулах, авлигын эрсдэлийг бодитой бууруулах, хөрөнгө оруулалтын таатай орчныг дэмжих, эрдэс баялагийн салбарыг хариуцлагатай, ил тод болгож, улсын болон орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлснээр ядуурлыг бууруулах, ард иргэдийн амьжирааг дээшлүүлэх, эдийн засгийн сэргэлт бүхий хөгжилд оруулах хувь нэмрийг бодитой, илүү өгөөжтэй болгох төрийн бодлогын ач холбогдол, өндөр хариуцлага руу чиглэж байна.

Н.Баярсайхан: Үндэсний зөвлөлийн дарга, УУХҮЯ-ны сайд Ёндон хурлаа удирдаж байхыг хурлын тэмдэглэлд тусгах саналтай байна.

Л.Төр-Од: Монгол улсад 2022 оны нэгдүгээр сараас эхлэн ОҮИТБС-ын 3 дахь баталгаажуулалт хийгдэх бөгөөд бид бэлтгэл сайтай оролцож амжилтаяа бататгах хариуцлагатай жилд орж байна. Иймд Ажлын хэсэг болон Үндэсний зөвлөлийн хуралдаанаар ОҮИТБС-ын 2019 онд хамгийн сүүлд шинэчилсэн стандарт шаардлагыг хангахад дутагдаж байгаа удирдлага зохион байгуулалт, бодлогын тулгамдаж буй асуудал, гаргах шаардлагатай шийдвэлийг нухацтай ярилцаж тодорхой зөвшилцэл бүхий шийдвэрт хүрэх ёстой гэж үзэж байна.

Н.Баярсайхан: Энэ хурал Ажлын хэсгийн хурлаас ч дор чанаргүй хурал боллоо гэж дүгнэж байна.

Л.Төр-Од: Дараах багц асуудлыг оруулж хэлэлцүүлэх тусгай саналтай байна. Үүнд: Жил бүрийн нэгтгэл тайлангаар гардаг дүгнэлтүүд болон багц зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэхгүй байгаа одоогийн нөхцөл байдлыг шийдвэрлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг Дэд зөвлөлийн төсөв санхүүжилтийн асуудлыг нэг мөр бүрэн шийдэх, идэвх санаачилга бага, хуралдаанд оролцдоггүй нийт яам, агентлагийн удирдлагад хариуцлага тооцох, хувийн хэвшлээс илүүтэй төрийн өмчтэй болон төрийн

өмчийн оролцоотой уул уурхайн компаниуд нь манлайлал үзүүлж ажиллах арга хэмжээг тодорхойлох гэх мэт чухал олон асуудал байна.

ТАН эвсэл нь эрдэс баялгийн салбарт сайн засаглал, ил тод байдал, хуулийн хэрэгжилтийг хангах зорилготой, төв болон орон нутгийн нийт 36 төрийн бус байгууллагыг эгнээндээ багтаасан иргэний нийгмийн эвсэл юм. ТАН эвсэл нь 2006 оноос эхлэн ОҮИТБС-ын хэрэгжилтэд иргэний нийгмийг төлөөлөн оролцож, ОҮИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн гишүүнээр өнөөг хүртэл идэвхтэй ажиллаж ирсэн болно.

МОНГОЛЫН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН
САНААЧИЛГЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН 20 ДУГААР
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Үндэсний зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 20 дугаар хуралдааны тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН нь:

“Монголын ОҮИТБС-ын 2020 оны уян хатан тайлан”-гийн төслийн танилцуулга, “Монголын ОҮИТБС-ын 2021 оны үйл ажиллагааны тайлан, 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний төслийн танилцуулга, Дэд зөвлөлүүдийн чадавхийн суурь хэрэгцээний талаарх судалгааны хүрээнд боловсруулсан “Дэд зөвлөлийг чадавхжуулах стратеги”-ийн төслийн танилцуулга, холбогдох бусад асуудал

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Монголын ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийн 20 дугаар хуралдаанаас дараах шийдвэрийг гаргахаар тогтов. Үүнд:

1. “Монголын ОҮИТБС-ын 2020 оны уян хатан тайлан”-гийн төслийг Үндэсний зөвлөлийн гишүүдийн санал, зөвлөмжийг нэмж тусган батлах;
2. Тайланг боловсруулсан “Грант Торnton Аудит” ХХК-тай байгуулсан “Ажил гүйцэтгэх гэрээ”-ний дагуу нийт төлбөрийн үлдэгдэл 10 хувийг холбогдох дансанд шилжүүлэхийг ОҮИТБС-ын Ажлын алба (Ш.Цолмон)-нд зөвшөөрөх;
3. Монголын ОҮИТБС-ын 2021 оны үйл ажиллагааны тайлан, үр дүнг хангалттай гэж үзэх;
4. Монголын ОҮИТБС-ын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд Монголын ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийн гишүүдийн санал, зөвлөмжийг тусган батлах;
5. Дэд зөвлөлүүдийн чадавхийн суурь хэрэгцээний талаарх судалгааны хүрээнд боловсруулсан “Дэд зөвлөлийг чадавхжуулах стратеги”-д Үндэсний зөвлөлийн гишүүдийн санал зөвлөмжийг нэмж тусган батлах нь зүйтэй гэж үзэв.

УУХҮЯ-НЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
МОНГОЛЫН ОҮИТБС-ЫН ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.НАНДИНЖАРГАЛ